



ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 02 сарын 11 өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот

Хөдөлмөрийн харилцааны хөтөлбөрт нэмэлт оруулах тухай

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.4 дэх заалт, 23 дугаар зүйлийн 23.1.11 дэх заалт, 28 дугаар зүйлийн 28.8.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Хөдөлмөрийн харилцааны хөтөлбөр"-т доор дурдсан агуулга бүхий заалтыг тус тус нэмсүгэй:

"5.6.1. зөвлөх үйлчилгээ үзүүлж буй мэргэшсэн зөвлөхийн аж ахуйн нэгж, байгууллага, ажил олгогч болон аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэстэй хамтран ажиллах ажлын төлөвлөгөө, үр дүнг үнэлэх шалгуур үзүүлэлт, ажлын чанар, гүйцэтгэлд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам хяналт тавина."

"6.5. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас мэргэшсэн зөвлөхийн үйлчилгээтэй холбоотой аж ахуйн нэгж, байгууллага, ажил олгогч, бусад байгууллагаас ирүүлсэн санал гомдлыг үндэслэн, гомдол үндэслэлтэй бол "мэргэшсэн зөвлөх"-ийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас зөвлөх үйлчилгээ, үйл ажиллагааг санхүүжүүлэхгүй байж болно."

2. Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хөдөлмөрийн бодлогын газрын дарга Д.Ренчиндорж, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Ц.Мөнхзул, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2025 онд батлагдсан төсвийн хүрээнд санхүүжилтийг хуваарилан, үйл ажиллагааны хэрэгжилтийн үр дүнг шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж тайлагнан, хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын дарга З.Энхболд нарт тус тус даалгасугай.

3. Хөдөлмөрийн харилцааны хөтөлбөрийн дагуу ажил олгогчид үзүүлэх сургалтын зөвлөх үйлчилгээг нийтэд хүртээмжтэй цахим сургалтын хэлбэрээр зохион байгуулах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын дарга З.Энхболдод даалгасугай.

4. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллахыг холбогдох байгууллагууд, Хөдөлмөр эрхлэлтийн аймаг, дүүргийн зөвлөл, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсийн дарга нарт тус тус даалгасугай.

ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА,
ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙД



Л.ЭНХ-АМГАЛАН